

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР,
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ДАРГЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2017 оны 05 сарын 30 өдөр

№ А/140,261 Улаанбаатар хот

Хамтран ажиллах журам
батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8.4-т заасныг үндэслэн Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх, байгууллага хоорондын хамтын ажиллагаа, уялдаа холбоо, мэдээлэл солилцоог сайжруулах зорилгоор ТУШААХ нь:

1. "Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газрын хамтран ажиллах журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газрын Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний хэлтэс /Т.Есөнтөмөр/ болон Гадаадын иргэн, харьяатын газрын Виз, зөвшөөрлийн газар /Ч.Нармандах/-т тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан "Журам батлах тухай" Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны даргын 2007 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн №139/307 дугаар хамтарсан тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗРЫН
ДАРГА

Б.НЯМДАВАА

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГА

Д.МӨРӨН

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газрын даргын хамтарсан 2017 оны 05 дугаар сарын 30 ны өдрийн 440/261 хамтарсан тушаалын хавсралт

**ХӨДӨЛМӨР, ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЕРӨНХИЙ ГАЗАР,
ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ХАМТРАН
АЖИЛЛАХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмын зорилго нь гадаадын иргэнийг Монгол Улсад хөдөлмөр эрхлэх үйл ажиллагааг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, Ажиллах хүч гадаадад гаргах, ажиллах хүч мэргэжилтэн гадаадад гаргах тухай Монгол Улсын хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийн дагуу зохион байгуулахад оршино.

1.2. Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар /цаашид "Ерөнхий газар" гэх/, Гадаадын иргэн, харьяатын газар /цаашид "Газар" гэх/ хоорондын ажлын уялдаа, мэдээлэл солилцох ажиллагааг эрчимжүүлэх, Монгол Улсад албан болон хувийн хэргээр оршин суух гадаадын иргэн, харьяалалгүй хүнд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, олгохоос татгалзах, олгосон зөвшөөрлийн хугацааг сунгах, хуульд заасан үндэслэлээр зөвшөөрлийг хүчингүй болгохтой холбогдсон үйл ажиллагааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Хамтын ажиллагаа

2.1. Гадаадын иргэний хөдөлмөр эрхлэлттэй холбоотой өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэх явцад үүссэн аливаа асуудлыг тухай бүр удирдлагын хэмжээнд уулзалт зохион байгуулан хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ.

2.2. Гадаадын иргэний хөдөлмөр эрхлэлтийн талаарх төрийн бодлогыг сурталчлах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах ажлыг хамтран зохион байгуулж, биелэлтэд хяналт тавина.

2.3. Ерөнхий газар болон Газар нь төрийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх зорилгоор жилд 5 хүртэл хоногоор албан хаагчдыг нэг цэгт байрлуулан ажиллуулна.

2.4. Шаардлагатай тохиолдолд гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авч ажиллуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллагад хамтарсан шалгалт зохион байгуулж болно.

Гурав. Гадаадын иргэнд хөдөлмөр эрхлэх оршин суух зөвшөөрөл
олгох, сунгах, хасалт хийх талаар авах зарим арга хэмжээ

3.1. Ерөнхий газар нь урьдчилсан зөвшөөрөл, хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгохдоо Засгийн газраас тогтоосон хувь хэмжээ /квот/, гадаад улсаас ажиллах хүч, мэргэжилтэн оруулах тухай Засгийн газрын тогтоолд заасан хэмжээг баримтлах бөгөөд Газартай тухай бүр мэдээлэл солилцоно.

3.2. Ерөнхий газраас олгосон хөдөлмөр эрхлэх урьдчилсан зөвшөөрөл, зөвшөөрөл олгох, сунгах, дуусгавар болгох зэрэг албан бичгийг үндэслэн Газар нь холбогдох үйлчилгээг гадаадын иргэнд үзүүлнэ.

3.3. Хөдөлмөр эрхлэх урьдчилсан зөвшөөрлийг хүчингүй болгосон, оршин суух зөвшөөрлийн хугацааг сунгахаас татгалзсан тохиолдолд талууд ажлын 10 хоногийн дотор албан бичгээр харилцан мэдэгдэж холбогдох арга хэмжээ авна.

3.4. Газар нь Засгийн газрын 2015 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам”-ын 2.3-т заасны дагуу гадаадын мэргэжилтэнд хасалт хийсэн тодорхойлолтыг Ерөнхий газарт гаргаж өгнө.

3.5. Засгийн газар хоорондын хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Засгийн газрын 2015 оны 41 дүгээр тогтоолоор баталсан “Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журам”-ын дагуу Монгол Улсад хувийн хэргээр оршин суугч, цагаач иргэн, харьяалалгүй хүнд Газраас олгосон оршин суух зөвшөөрлийн үнэмлэхийг үндэслэн Ерөнхий газар хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийг олгоно.

3.6. Хөдөлмөр эрхлэгч гадаадын иргэн хүндэтгэн үзэх шалтгаанаар Монгол Улсаас гарах тохиолдолд уригч байгууллагын албан бичгийг үндэслэн Газар нь хилийн боомтоор гаргах бөгөөд энэ тухай Ерөнхий газарт мэдэгдэнэ.

Дөрөв. Мэдээлэл солилцоо

4.1. Үндэсний аюулгүй байдлын эсрэг үйл ажиллагаа явуулж болзошгүй гэж эрх бүхий байгууллагаас үзсэн улс орнуудаас хөдөлмөр эрхлэхээр орж ирэх мэргэжилтэнд хөдөлмөр эрхлэх урьдчилсан зөвшөөрөл /урилга/ авахаас өмнө Газраас зөвшөөрөл олгосны үндсэн дээр Ерөнхий газар хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн үйлчилгээг үзүүлж болно.

4.2. Хууль бусаар хөдөлмөр эрхлүүлж буй аж ахуйн нэгж, байгууллагын судалгаа, мэдээллийг Газар нь сар бүрийн 25-ны дотор Ерөнхий газрын Ажиллах хүч, шилжилт хөдөлгөөний хэлтэст цахимаар хүргүүлнэ.

4.3. Үндэсний ДАТА төвд байрлах “Төрийн цахим мэдээллийн нэгдсэн сан” дахь хөдөлмөр эрхлэгч гадаадын иргэний талаарх мэдээллийг харилцан солилцохдоо холбогдох гэрээг байгуулан ажиллана.

4.4. Хөдөлмөр эрхлэх оршин суух зөвшөөрөлтэй гадаадын иргэн хасалт хийлгэсэн талаарх мэдээллийг Үндэсний ДАТА төвд байрлах “Төрийн цахим мэдээллийн нэгдсэн сан”-аар дамжуулан цахим хэлбэрээр харах, боломжгүй тохиолдолд улирал тутам албан бичгээр эсхүл Ерөнхий газрын axshxx@hudulmur-halami.gov.mn, Газрын visasection@immigration.gov.mn цахим хаягаар харилцан солилцоно.

4.5. Ерөнхий газар болон Газар нь хамтран ажиллах журмын дагуу авч хэрэгжүүлсэн ажлын үр дүнг жил бүрийн 12 дугаар сарын 10-ны дотор тайлагнан, биелэлтийг дүгнэнэ.

Тав. Бусад зүйл

5.1. Энэхүү журмын зүйл заалтад талууд санал нэгдсэний үндсэн дээр Ерөнхий газар, Газрын дарга нарын хамтарсан тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулж болно.